

# Көртландын сүмд сэргээгдсэн санваарын түлхүүрүүд

## Судлах үйл ажиллагаа А СУРГААЛ БА ГЭРЭЭ 110:11

Моше “Израилыг цуглуулах” (Сургаал ба Гэрээ 110:11) түлхүүрүүдийг сэргээв. Цуглуулах түлхүүрүүд нь Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг дэлхийн үндэстнүүдэд тунхаглах эрх мэдэл бүхий үйлчлэгчдэд эрх мэдэл өгдөг.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн тунхаглажээ.



Бид хөшигний хоёр талд Израилыг цуглуулах ажлын талаар ярихдаа мэдээж номлол, ариун сүм, гэр бүлийн түүхийн ажлын тухай ярьдаг. Бид мөн хамт амьдардаг, ажилладаг, үйлчилдэг хүмүүсийнхээ зүрх сэтгэлд итгэл, гэрчлэлийг нь бататгах тухай ярьдаг. (Рассэлл М.Нэлсон, “Бурхан ялах болтугай,” 2020 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 102)

- Та өдөр бүр харилцдаг хүмүүсийнхээ зүрх сэтгэлд итгэл, гэрчлэлтэй болоход нь хэрхэн тусалж чадах вэ?
- Их Эзэн номлолын ажлаар дамжуулан бидэнд хандсан нь таны амьдралд эсвэл таны таньдаг хэн нэгний амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

## Судлах үйл ажиллагаа Б СУРГААЛ БА ГЭРЭЭ 110:12

Елиас Абрахамын сайн мэдээний эрин үеийг даатгав (Сургаал ба Гэрээ 110:12). Үүнд Абрахамын гэрээний сэргээлт багтана.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн тайлбарласан.



Бурханы Абрахамтай эхэлж хийсэн гэрээ . . . үүнд хэд хэдэн амлалтууд орсон . . . бүх үндэстнүүд түүний үр удмаар адислагдах болно. . . .

. . . Бид эрт үеийн хүмүүстэй адил ариун санваар болон мөнхийн сургаалыг хүлээн авсан. Бид сургаалын бүрэн байдлыг хүлээн авч, санваарын адислалуудыг хүртэж, Бурханы хамгийн агуу том бэлэг болох мөнхийн амьдралыг авах эрхтэй болсон. (Рассэлл М.Нэлсон, “Гэрээнүүд,” 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 103)

- Их Эзэн сайн мэдээ, санваараараа дамжуулан үндэстэн, гэр бүлүүд, хувь хүмүүсийг ямар арга замаар адисалдаг вэ?
- Та Их Эзэний сайн мэдээгээр болон санваараар дамжуулан Түүнээс ямар адислал хүлээн авч байна вэ?